



Сүхбаатар аймаг дахь Төрийн
аудитын газар

АУДИТЫН ТАЙЛАН

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СБА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Баруун-Урт сум 2023 он



Дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитор Ө.Золзаяа

Утас: 70512127 Цахим хаяг: Zolzayau@audit.gov.mn

Аудитор О.Барчидгүнсэн

Утас: 70512127 Цахим хаяг: Barchidgunseno@audit.gov.mn

Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	4
БҮЛЭГ 1. Малын тоо толгойд ногдуулах албан татвар 622.6 сая төгрөг буюу 35 хувиар тасарсан бөгөөд бүрэн төвлөрүүлэх чиглэлд төрийн байгууллагууд идэвх санаачилгагүй байна.	6
<i>А.1 Орон нутгийн төсөвт төвлөрөөгүй 4,183.2 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг санхүүгийн тайланд гүйцэтгэлээр илэрхийлж, орлогыг илүү илэрхийлсэн.....</i>	<i>6</i>
<i>А.1.1 Орон нутгийн төсвийг Төсвийн тухай хууль, бусад эрх зүйн актад нийцүүлэн төлөвлөжээ.</i>	<i>6</i>
<i>А.1.2 Орон нутгийн төсвийн орлого 7,237.4 сая төгрөг буюу 12 хувиар тасарчээ.....</i>	<i>7</i>
<i>А.1.2.1 Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл:</i>	<i>8</i>
<i>А.1.2.2 ААНОАТ-ын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмын хэрэгжилт:</i>	<i>9</i>
<i>А.1.2.3 Бусад орлогын гүйцэтгэл:.....</i>	<i>9</i>
БҮЛЭГ 2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, зээлийн хүүгийн төлбөр 4,183.2 сая төгрөгийг орхигдуулсан байна.	10
Б.2 Орон нутгийн төсвийн зарлагын 61 хувийг урсгал зардал, 39 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.....	10
<i>Б.2.1 Орон нутгийн төсвийн зарлагыг 61,796.7 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 1,869.9 сая төгрөгөөр бууруулсан байна.</i>	<i>10</i>
<i>Б.2.2 Хөрөнгө худалдан авах гэрээнд тусгагдаагүй зөөврийн компьютерыг 185.0 сая төгрөгөөр худалдан авчээ.</i>	<i>10</i>
БҮЛЭГ 3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 277.9 сая төгрөгийн зөрчил илрүүлээ.	13
В.1 Зарим төсөвт байгууллага, ИТХ, Засаг дарга, ОНӨААТҮГ-ууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад хангалтгүй ажилласан байна.	13
БҮЛЭГ 4. Тайлант онд нийт 451 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 24,944.3 сая төгрөгийг баталжээ.	15
<i>Г.1. Төсөл арга хэмжээний зураг төсөв боловсрогдоогүй, тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, шалгуур хангаагүй зэрэг шалтгаанаар 13 арга хэмжээний 930.2 сая төгрөг олгогдоогүй үлдсэн байна.</i>	<i>15</i>
<i>Г.1.1 Их засварын 7 төсөл арга хэмжээнээс 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий засварын ажил хийгдээгүй байна.</i>	<i>16</i>
<i>Г.1.2 Удирдлагыг хэрэгжүүлэх зардал 78 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2 төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.....</i>	<i>17</i>

Г.1.3 Авто замын сангаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ 85 хувийн гүйцэтгэлтэй байна. 18

БҮЛЭГ 5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, танилцуулгын хамт бэлтгэгдээгүй байна..... 18

Д.1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан зарим шалгуурт нийцүүлэн тайлагнаагүй байна. 18

БҮЛЭГ 6. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ 19

ДҮГНЭЛТ 20

ЗӨВЛӨМЖ: 21

САНАЛ: 21

Холбогдох байгууллагын санал..... 23



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
MNS	Монгол улсын стандарт

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График №1	Төсвийн орлогын төлөвлөлт
Хүснэгт №1	Төсвийн орлогын гүйцэтгэл
Хүснэгт №2	Орон нутгийн 2022 оны төсвийн зарлагын төлөвлөгөө
Хүснэгт №3	Төсвийн зарлагын гүйцэтгэл
Хүснэгт №4	Бараа, ажил үйлчилгээ худалдан авсан судалгаа
Хүснэгт № 5	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн, шийдвэрлэлт
Хүснэгт № 6	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Хүснэгт №7	Их засварын зардлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
Хүснэгт № 8	Удирдлага болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаар гүйцэтгэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Хүснэгт №9	Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Хүснэгт№ 10	Төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр/
Диаграм №1	Орон нутгийн нэгдсэн төсвийн нэмэлт төсвийн санхүүжилт

<p>Аудит үндэслэл, эрх</p>	<p>хийх бүрэн</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэв.</p>
<p>Аудитын зорилт</p>		<p>Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн ИТХ болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахад дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 2022 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх 2. 2022 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх 3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 4. Тухайн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэл 5. Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх 6. Нэмэлт төсвийн гүйцэтгэл
<p>Аудитын хүрээ</p>	<p>хамарсан</p>	<p>Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Сангийн яамнаас Сүхбаатар аймгийн 2022 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>		<p>Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>		<p>Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор О.Барчидгүнсэн, Ө.Золзаяа нар гүйцэтгэв.</p>

БҮЛЭГ 1. Малын тоо толгойд ногдуулах албан татвар 622.6 сая төгрөг буюу 35 хувиар тасарсан бөгөөд бүрэн төвлөрүүлэх чиглэлд төрийн байгууллагууд идэвх санаачилгагүй байна.

А.1 Орон нутгийн төсөвт төвлөрөөгүй 4,183.2 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг санхүүгийн тайланд гүйцэтгэлээр илэрхийлж, орлогыг илүү илэрхийлсэн.

А.1.1 Орон нутгийн төсвийг Төсвийн тухай хууль, бусад эрх зүйн актад нийцүүлэн төлөвлөжээ.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар Сүхбаатар аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 6,690.8 сая, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 12,058.7 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Сүхбаатар аймгийн 2022 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1¹, 57 дугаар зүйлийн 57.2², 57.3³ дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах" журам, аймгийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.

Сүхбаатар аймгийн 2022 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.2-т заасан цаглабарын дагуу тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлжээ.

Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 3 тоот тогтоол болон сумдын ИТХ-ын "2022 оны төсөв батлах тухай" тогтоолоор Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 61,796.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2⁴-д заасны дагуу Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын "Төсвийн тодотгол батлах тухай" тогтоолд төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,869.9 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

График №1 Төсвийн орлогын төлөвлөлт /сая төгрөг/



Эх сурвалж: Аймаг, сумын төсөв батлах, тодотгох тухай тогтоол

¹ Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна

² Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ

³ Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна

⁴ тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

Аймаг, сумдын ИТХ-аар татварын орлогыг 194.3 сая, татварын бус орлогыг 59.4 сая төгрөгөөр нэмж, хөрөнгийн орлогыг 500.0 сая, тусламж санхүүжилтийн орлогыг 1,623.7 сая төгрөгөөр бууруулан баталсан.

А.1.2 Орон нутгийн төсвийн орлого 7,237.4 сая төгрөг буюу 12 хувиар тасарчээ.

Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд 2022 оны төсвийн нийт орлого, тусламжийн дүнг 59,926.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс 52,689.4 сая төгрөг буюу 88 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №1 Төсвийн орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	1.0	1.0	/2-1/	/2:1/
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	59,926.7	52,689.4	(7,237.4)	88
НИЙТ ОРЛОГО	26,114.9	31,539.1	5,424.2	121
УРСГАЛ ОРЛОГО	26,064.9	31,465.5	5,400.6	121
ТАТВАРЫН ОРЛОГО	20,246.5	28,295.3	8,048.8	140
Орлогын албан татвар	7,658.0	8,618.8	960.8	113
Хүн амын орлогын албан татвар	7,658.0	8,618.8	960.8	113
ААН-ын орлогын албан татвар	7,696.5	13,816.4	6,119.9	180
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	6,301.1	7,385.4	1,084.4	117
Буцаан олголт	(449.8)	(450.2)	(0.4)	100
Үйл ажиллагааны орлого	681.2	585.7	(95.5)	86
Хөрөнгийн орлого	951.0	828.8	(122.2)	87
Хөрөнгө борлуулсны орлогын	125.5	131.7	6.2	105
Шууд бус орлого	49.1	137.4	88.3	280
Өмчийн татвар	2,491.0	1,871.6	(619.4)	75
Үл хөдлөх хөрөнгийн татвар	658.2	667.0	1.8	102
Малын тоо толгойн албан татвар	1,803.0	1,180.4	(622.6)	65
Бууны албан татвар	29.8	24.1	(5.7)	81
Дотоодын бараа ажил үйлчилгээний татвар	440.0	514.2	74.2	117
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн	440.0	514.2	74.2	117
Бусад татвар /төлбөр хураамж/	1,961.0	3,474.3	1,513.3	177
Улсын тэмдэгтийн хураамж	140.9	147.2	6.3	104
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	203.6	152.3	(51.3)	75
Газрын төлбөр	520.3	309.3	(211.0)	59
Газрын төлбөр	520.3	309.3	(211.0)	59
дуудлага худалдаа	9.0	804.3	795.3	8,937
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	47.1	11.2	(35.9)	24
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,040.0	2,025.5	985.5	195
Рашаан,ус ашигласны төлбөр	515.3	603.1	87.8	117
Байгалын ургамлын нөөц ашигласны төлбөр	48.5	56.1	7.6	116
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	476.3	1,366.3	890.1	287
Бусад татвар	-	24.4	24.4	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,818.4	3,170.2	(2,648.2)	54
Хүү, торгуулийн орлого	1,191.0	907.6	(283.4)	76
Бусад орлого	4,627.4	2,262.6	(2,364.8)	49
Хөрөнгө худалдсаны орлого	50.0	73.6	23.6	147
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны	50.0	73.6	23.6	147
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	18,749.5	18,523.3	(226.1)	99

ОНХСангийн орлогын шилжүүлэг	12,058.7	11,832.5	(226.1)	98
Санхүүгийн дэмжлэг	6,690.8	6,690.8	-	100
СУМДЫН ТУСГАЙ САНГУУД	3,387.2	2,627.0	(760.2)	78
Төсөл сан / орлого /	2,467.3	1,792.7	(674.7)	73
Сум хөгжүүлэх сан орлого	919.8	834.3	(85.5)	91
УРЬД ОНЫ ҮЛДЭГДЭЛ	11,675.2			

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

А.1.2.1 Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл:

Тайлант онд татварын орлогын гүйцэтгэл 28,295.3 сая төгрөг буюу төлөвлөснөөс 8,048.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогоос 7 нэр төрлийн орлого 24-87 хувийн гүйцэтгэлтэй буюу нийт 1,144.2 сая төгрөгөөр тасарсан байна. Тухайлбал:

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 24, газрын төлбөр 59, малын тоо толгойн албан татвар 65, хог хаягдлын үйлчилгээний хураамж 75, бууны албан татвар 81, хөрөнгийн орлого 87 хувийн биелэлттэй байна. Энэ нь зарим сумд хог хаягдлын хураамжийн төлбөрийг ИТХ-аар батлуулаагүй, хадгаламжийн хүү буурсан, иргэдийн үйл ажиллагааны орлогын дүн 50.0 сая төгрөгөөс доош үед хялбаршуулсан горимоор татвар ногдуулсан, тайлант онд 58 галт зэвсгийг бүртгэлээс хассан болон газрын төлбөр, малын тоо толгойд ногдуулах албан татварын орлогыг бүрдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүйтэй холбоотой байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр багийн Засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэх зөвлөмж хүргүүлээ.

Харин 12 нэр төрлийн орлого төлөвлөснөөс 9,193.3 сая төгрөгөөр давсан гүйцэтгэлтэй байна. Тухайлбал:

- Үл хөдлөх хөрөнгийн татвар, улсын тэмдэгтийн хураамж, хөрөнгө борлуулсны орлогын татвар 101-105 хувь, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар, рашаан ус ашигласны төлбөр, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвар 116-117 хувь, ААН-ийн орлогын албан татвар, шууд бус орлого, ан амьтны нөөц ашигласны төлбөр, дуудлага худалдаа 180-аас дээш хувиар давж биелжээ. Гол нөлөөлөл нь өмнөх онуудад хийсэн хяналт шалгалтын төлбөрийг барагдуулсан, 11 суманд идлэг шонхор шувууны хураамж хуваарилсан, дуудлага худалдааны орлого өссөн болон ААНОАТ-ын 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж буйтай холбоотой байна.

Татварын бус орлогыг 5,818.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэл 3,170.2 сая төгрөг буюу 54 хувьтай байна. Үүнд:

- Хүү торгуулийн орлого 283.4 сая, бусад орлого 2,364.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Бусад орлого жил дараалан гүйцэтгэл хангалтгүй биелж байгаа нь тухайн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн санал оруулж батлуулдаг бөгөөд тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагууд Төсвийн Ерөнхийлөн захирагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсан байдаг. Гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд төсөвт төвлөрүүлэх хандив тусламжийн орлогыг үйл ажиллагаа хэвийн

явуулаагүй гэх мэт шалтгаан тоочиж, бүрэн төвлөрүүлэхгүй байгаа нь татварын бус орлогын гүйцэтгэлд гол нөлөөллийг үзүүлж байна.

Татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүүтэй байгаа байдал нь орлогын төлөвлөлттэй шууд холбоотой бөгөөд ан амьтны нөөц ашигласны төлбөр, хүү торгуулийн орлого, дуудлага худалдааны орлого зэргийг урьдчилан төлөвлөх боломжгүй тул өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөсөн, бусад нэр төрлийн орлогыг төвлөрүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүйтэй холбоотой байна.

A.1.2.2 ААНОАТ-ын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмын хэрэгжилт:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдсантай холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-д заасны дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Сангийн яамнаас уг татварыг 6,400.0 сая төгрөгөөр хянасан ба орон нутаг 7,696.5 сая төгрөгөөр төлөвлөж баталсан бөгөөд гүйцэтгэлээр 13,816.4 сая төгрөг төвлөрснөөр илэрхийлжээ.

Сангийн яамнаас аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос орон нутгийн төсөвт 9,637.2 сая төгрөгийг хуваарилж, үлдэгдэл 4,183.2 сая төгрөгийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, зээлийн хүүгийн төлбөрт аймгийн Засаг даргын албан тоотын дагуу суутган тооцсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10⁵ дахь заалт, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9⁶ дэх заалтыг зөрчсөн байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх нөхцөлтэй, хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг аймгийн ИТХ-д санал оруулж батлуулаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5⁷ дахь заалтыг зөрчсөн байна. Мөн Сүхбаатар аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгагдахгүй орхигдсон байна.

Сангийн сайдын 2022 оны А7 дугаар тушаалаар батлагдсан “ААНОАТ-ын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын 3.8⁸ дахь заалт нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10 дахь заалттай нийцээгүй байна.

A.1.2.3 Бусад орлогын гүйцэтгэл:

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө худалдсаны орлого 23.6 сая төгрөгөөр давж биелсэн, ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 226.1 сая, сумдын төсөл сангийн орлого 760.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

⁵ аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь

⁶ Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах

⁷ хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх

⁸ аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын тухайн жилийн төсвийн батлагдсан төлөвлөгөөний дүнгээс давсан бол аймаг, нийслэлийн төсөвт хуваарилахгүй

БҮЛЭГ 2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, зээлийн хүүгийн төлбөр 4,183.2 сая төгрөгийг орхигдуулсан байна.

Б.2 Орон нутгийн төсвийн зарлагын 61 хувийг урсгал зардал, 39 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Б.2.1 Орон нутгийн төсвийн зарлагыг 61,796.7 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 1,869.9 сая төгрөгөөр бууруулсан байна.

Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2021 оны 03 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “2022 оны төсөв батлах тухай” тогтоолд Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн нийт зарлагыг 61,796.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1⁹ дэх, 64 дүгээр зүйлийн 64.1.2¹⁰-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 10 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолоор 2022 оны төсвийн нийт зарлагыг 1,869.9 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн 2022 оны төсвийн зарлагын төлөвлөгөө /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгосон	Зөрүү
А	1	2	(2-1)
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,796.7	59,926.7	(1,869.9)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,041.2	31,889.7	(2,151.6)
ТАТААС	280.0	437.2	157.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	795.6	922.3	126.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,650.3	24,443.7	(206.6)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,029.6	2,233.8	204.2

Эх сурвалж: Сүхбаатар аймаг, сумдын төсөв батлах, тодотгох тухай тогтоол

Төсвийн тодотголоор бараа, ажил үйлчилгээний зардлыг 2,151.6 сая, хөрөнгийн зардлыг 206.6 сая төгрөгөөр тус тус бууруулж, төрийн өмчийн байгууллагад олгох татаасыг 157.2 сая, урсгал шилжүүлгийг 126.8 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийг 204.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Б.2.2 Хөрөнгө худалдан авах гэрээнд тусгагдаагүй зөөврийн компьютерыг 185.0 сая төгрөгөөр худалдан авчээ.

Сүхбаатар аймгийн 2022 оны төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 50,520.1 сая төгрөг буюу 84.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №3 Төсвийн зарлагын гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2022 он		
		Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	3	4	5=3-4
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,555.6	59,926.7	50,520.1	9,406.6
УРСГАЛ ЗАРДАЛ	56,687.9	33,249.2	30,041.3	3,207.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,040.6	31,889.7	28,855.0	3,034.7

⁹ дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон

¹⁰ тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,039.7	8,380.9	8,025.1	355.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,298.1	1,047.9	998.9	49.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,223.9	6,707.8	6,038.9	668.9
Хангамж, бараа материалын зардал	1,220.1	736.1	701.4	34.7
Нормативт зардал	1,485.1	17.0	14.3	2.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,261.0	1,529.4	1,396.2	133.2
Томилолт, зочны зардал	121.5	244.2	219.7	24.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,147.4	4,086.0	3,917.6	168.4
Бараа үйлчилгээний бусад зардал	5,243.8	9,140.4	7,542.9	1,597.5
ТАТААС	245.2	437.2	330.0	107.2
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	107.2	107.2	-	107.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	138.0	330.0	330.0	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,402.0	922.3	856.3	66.0
Бусад урсгал шилжүүлэг	1,402.0	922.3	856.3	66.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,013.2	24,443.7	19,802.8	4,640.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	854.6	2,233.8	676.0	1,557.8
Сум хөгжүүлэх сан	854.6	2,233.8	676.0	1,557.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	76,341.3	59,926.7	47,358.5	12,568.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,878.6	12,058.7	11,832.5	226.2
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	48,878.6	12,058.7	11,832.5	226.2
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,370.8	37,708.8	32,898.9	4,809.9
Орон нутгийн төсвөөс	24,370.8	37,708.8	32,898.9	4,809.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,836.8	10,159.2	2,627.1	7,532.1
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	255.1	-	-	-

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Харилцах дансны эхний үлдэгдэл 6,781.4 сая гүйцэтгэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшил 8,025.1 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 998.9 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,038.9 сая, хангамж, бараа материал 701.4 сая, нормативд зардал 14.3 сая, эд хогшил, урсгал засвар 1,396.2 сая, албан томилолт 219.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 3,917.6 сая, бараа үйлчилгээний бусад зардал 7,542.9 сая, төрийн өмчит байгууллагад шилжүүлэх татаас 330.0 сая, бусад урсгал шилжүүлэг 856.3 сая, хөрөнгийн зардалд 19,802.8 сая, хоршоо хөгжүүлэх сангийн зээл 676.0 сая нийт 50,520.1 сая төгрөг зарцуулж, харилцах дансны эцсийн үлдэгдэл 3,577.2 сая төгрөг байна.

Орон нутгийн төсвийн зарлагын 61 хувийг урсгал зардал, 39 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:1

Зөөврийн компьютер, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж худалдан авахад орон нутгийн төсвийн байгууллагууд 182.0 сая, тусгай шилжүүлгийн байгууллагууд 122.0 сая нийт 303.0 сая төгрөг зарцуулжээ. Тусгай шилжүүлгийн байгууллагуудад байр ашиглалт, урсгал зардлаас бусад хэлбэрээр 122.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6¹¹ дахь заалттай нийцээгүй байна.

Хүснэгт №4 Бараа, ажил үйлчилгээ худалдан авсан судалгаа /сая төгрөг/

Байгууллага	Зөөврийн компьютер	Нягтлан бодох бүртгэлийн программ
-------------	--------------------	-----------------------------------

¹¹ тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх

	тоо	нэгжийн үнэ	нийт дүн	тоо	нэгжийн үнэ	нийт дүн
Орон нутгийн төсвийн байгууллага						
Аймаг сумын Иргэдийн төлөөлөгчийн хурал	14	2.5	35.0	14	2.0	28.0
Аймаг сумын Засаг даргын тамгын газар	30	2.5	75.0	15	2.0	30.0
Орон нутгийн өмчийн газар	1	2.5	2.5	1	2.0	2.0
Санхүү хяналт аудитын алба	1	2.5	2.5	1	2.0	2.0
Байгаль орчны газар	1	2.5	2.5	1	2.0	2.0
дүн	47	2.5	118.0	32	2.0	64.0
Тусгай шилжүүлгийн байгууллага						
Сумын соёлын төв	12	2.5	30.0	12	2.0	24.0
Хөгжилт жүжгийн театр	1	2.5	2.5	1	2.0	2.0
Угсаатны зүйн музей	1	2.5	2.5	1	2.0	2.0
Нийтийн номын сан	1	2.5	2.5	1	2.0	2.0
Сумын эрүүл мэндийн төв	12	2.5	30.0	12	2.0	24.0
дүн	27	2.5	68.0	27	2.0	54.0
НИЙТ ДҮН	74	2.5	185.0	59	2.0	118.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагууд үндсэн хөрөнгө (зөөврийн компьютер, программ хангамж)-ийг Си Ти Эс ХХК-тай “нягтлан бодох бүртгэлийн программ хангамж, ажил үйлчилгээ, ашиглалтын зөвлөгөө өгөх, ажил гүйцэтгэх гэрээ”-г үндэслэн шууд худалдан авалт хийжээ.

Аймгийн хэмжээнд нэр, төрөл, ажил үйлчилгээний зориулалтаар багцлан (зөөврийн компьютер 185.0 сая, программ хангамж 118.0) нийт үнийн дүнгээр худалдан авах ажиллагааны журмыг сонгож, худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹² дэх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4¹³ дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн Си Ти Эс программ нь онлайн орчинд ажилладаг бөгөөд байгууллагын нягтлан бодогч нарт компьютер техник хангамж бүртгэлээр байж байхад тус программыг дагалдуулан гэрээнд тусгагдаагүй зөөврийн компьютер худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁴ дахь, 41 дүгээр зүйлийн 41.2.3¹⁵ дахь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1¹⁶ дэх заалттай нийцээгүй төсвийн зарцуулалт байна.

Иймд аудитын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж, тухайн асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, эрсдэл бүхий асуудалд чиглэсэн аудит гүйцэтгэхээр болов.

Аудитын илрүүлэлт:2

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “... өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ” заасан байна. Гэтэл орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн зарим газрууд олсон орлогоороо өөрийгөө санхүүжүүлж чадахгүй, төсвөөс санхүүгийн дэмжлэг авч, төсвийн

¹² Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална

¹³ хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох

¹⁴ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹⁵ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

¹⁶ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно

гүйцэтгэлд зарлага бий болгосон байна. Тухайлбал: Бичигт их өргөө 50.0 сая, Сүхбаатар хөгжил, үйлдвэр технологийн парк 46.0 сая, Бичигт хөгжил 74.3 сая нийт 170.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁷ дэх заалтад нийцэхгүй байна. Иймд ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн, орон нутгийн санхүүгийн дэмжлэгээс бусад орлогын эх үүсвэргүй, өөрийгөө санхүүжүүлэн бие даан үйл ажиллагаа явуулах чадамжгүй газруудад дүн шинжилгээ хийж, хуулийн дагуу арга хэмжээ авах саналыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүллээ.

БҮЛЭГ 3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 277.9 сая төгрөгийн зөрчил илрүүллээ.

В.1 Зарим төсөвт байгууллага, ИТХ, Засаг дарга, ОНӨААТҮГ-ууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад хангалтгүй ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг УИХ-аас 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр баталсан бөгөөд тухайн өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн хэмжээнд 13 төсвийн төвлөрүүлэн захирагч, 59 төсвийн байгууллага, төсөл сан, 17 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, нийт 89 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хамрагдсан.

Сүхбаатар аймгийн төсөвт байгууллага, төсөл сан, ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа байгууллагуудад нийт 277.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 20.2 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 218.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 31 албан шаардлага, дотоод хяналт, үр ашгийг дээшлүүлэх 39.4 сая төгрөгийн 47 зөвлөмж өгсөн.

Хүснэгт № 5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн, шийдвэрлэлт /сая.төг/

№	Хуулийн зүйл	Хязгаарлалт	Тоо	Мөнгөн дүн	үүнээс					
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйл	Тэргүүн дэд, дэд, орлогч дарга	3	8.9	3	8.9	-	-	-	-
2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл	Тээврийн хэрэгсэл	1	5.6	-	-	1	5.6	-	-
3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дугаар зүйл	Албан томилолт	1	1.1	1	1.1	-	-	-	-
4	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйл	Цалин хөлс, нэмэгдэл	7	4.0	1	4.0	-	-	0	-
5	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл	Бусад хангамж	7	24.2	4	2.0	3	22.2	-	-
6	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	9	147.5	-	-	9	147.5	-	-
7	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйл	Цахим худалдан авалт	7	40.9	-	-	1	9.1	6	31.8
8	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл	Хэмнэлтийн бусад арга хэмжээ	8	45.7	3	4.2	2	33.9	3	7.6
9	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйл	Шилэн дансны тухай хууль	35	-	-	-	19	-	16	-
НИЙТ			78	277.9	12	20.2	35	218.3	31	39.4

Эх сурвалж: Сүхбаатар аймаг, сумдын төсөв батлах, тодотгох тухай тогтоол

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 2 дугаар бүлэгт заасан хязгаарлалтуудын талаар:

¹⁷ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

-Тэргүүн дэд, дэд, орлогч дарга:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно” заасныг зөрчиж, Аймгийн Засаг дарга хууль хэрэгжиж эхэлсэн хугацаанаас хойш орлогчийг 4 сар ажиллуулж 5.1 сая төгрөгийн цалин олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д “Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно” заасныг зөрчиж, Баруун-Урт, Баяндэлгэр сумын ИТХ-ын дарга нар зөвлөх ажиллуулж 3.8 сая төгрөгийн цалин олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

- Тээврийн хэрэгсэл:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэж заасныг зөрчиж, Сүхбаатар аймгийн Сүхбаатар хөгжил үйлдвэрлэлийн технологийн парк ОНӨААТҮГ-ын дарга дотор хэрэгцээнд өөрийн эзэмшлийн авто тээврийн хэрэгслийг ашиглаж 5.6 сая төгрөгийн түлш зарцуулсанд албан шаардлага хүргүүлээ.

-Албан томилолт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.” заасныг зөрчиж, албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчдын хоол, хүнсний материалд 1.1 сая төгрөг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

-Цалин хөлс, нэмэгдэл:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.” заасны дагуу цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй ОНӨААТҮГ-т 6 зөвлөмж хүргүүлж, 4.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

-Бусад хангамж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-3-д “хэвлэлийн захиалгын төлбөр” заасныг зөрчиж 1.6 сая төгрөгийн хэвлэл захиалсан 2 байгууллагад төлбөрийн акт тогтоов.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-4-д “ хуулиар зөвшөөрөөгүй бусад” заалтыг зөрчиж үр ашиггүй зардал гаргасан 0.4 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 22.2 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

-Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2 “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ”, 13.3.3 дахь “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” хориглосон заалтыг зөрчсөн 9 асуудалд 147.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

- Цахим худалдан авалт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах

ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” заасныг зөрчиж, тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлээгүй худалдан авалт хийсэн 1 байгууллагад зөвлөмж хүргүүлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” заасныг зөрчиж цахим дэлгүүрт байршсан бараанаас худалдан авалт хийгээгүй нийт 9.1 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 31.8 сая төгрөгийн 5 асуудалд зөвлөмж хүргүүлээ.

-Хэмнэлтийн бусад арга хэмжээ:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” заасанд хамаарах материаллаг зөрчилд хамаарахгүй 4.8 сая төгрөгийн асуудалд 2 зөвлөмж хүргүүлж, .

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” заасныг зөрчиж, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авч зориулалт бус зарцуулсан 2.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” заасныг зөрчиж, худалдан авалт хийж бараа материалыг нөөцөлсөн 3.0 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д “Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.” заасныг зөрчиж, хүлээн авалтын бараа материал худалдан авч зориулалт бус зарцуулсан 1.8 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж, өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй авлага, өр төлбөртэй холбоотой 30.9 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

-Тайлагналт, ил тод байдал:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна.” зөрчсөн 19 байгууллагад албан шаардлага хүргүүлж, 16 байгууллагад зөвлөмж хүргүүлээ.

Зарим төсөвт байгууллага, ИТХ, Засаг дарга, ОНӨААТҮГ-ууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад хангалтгүй ажилласан байна. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой шаталсан сургалт өгөх, төсвийг үр ашиггүй зарцуулсан, хэмнэлтийн горимыг зөрчсөн төсөв захирагчид тохирсон хариуцлагын механизмтай болох шаардлагатай байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2-т заасны дагуу хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

БҮЛЭГ 4. Тайлант онд нийт 451 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 24,944.3 сая төгрөгийг баталжээ.

Г.1. Төсөл арга хэмжээний зураг төсөв боловсрогдоогүй, тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, шалгуур хангаагүй зэрэг шалтгаанаар 13 арга хэмжээний 930.2 сая төгрөг олгогдоогүй үлдсэн байна.

Тайлант онд Сүхбаатар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 35,308.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 427 төсөл арга хэмжээг 22,983.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталжээ.

Хүснэгт № 6 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл /сая төгрөг/

№	Сум	ТАХ-ий тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Асгат	20	414.2	361.4	338.6	22.8
2	Баяндэлгэр	36	1,201.5	1,201.5	1,037.7	163.8
3	Дарьганга	22	585.1	585.1	345.9	239.2
4	Мөнххаан	30	947.6	947.6	740.6	207.0
5	Наран	21	467.5	441.6	343.7	97.9
6	Онгон	19	965.9	965.9	645.2	320.7
7	Түвшинширээ	36	578.9	541.4	458.5	82.9
8	Түмэнцогт	22	767.2	318.2	212.5	105.7
9	Сүхбаатар	24	4,937.3	2,000.0	1,772.5	227.5
10	Уулбаян	14	491.8	491.8	393.8	98.0
11	Халзан	14	256.4	256.4	155.5	100.9
12	Эрдэнэцагаан	64	1,828.3	1,828.3	1,228.5	599.8
13	Баруун-Урт	45	2,079.5	1,336.4	882.3	454.1
Сумдын дүн		367	15,521.2	11,275.6	8,555.3	2,720.3
Аймгийн дүн		60	19,787.4	11,707.7	10,045.4	1,662.3
НИЙТ		427	35,308.6	22,983.3	18,600.7	4,382.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх оноос шилжиж ирсэн 15 төсөл, арга хэмжээг 5,207.8 сая, шинээр хэрэгжиж буй 45 төсөл арга хэмжээг 6,450.0 сая, нийт 60 төсөл арга хэмжээг 11,707.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 7,786.7 сая төгрөг буюу 86 хувийн гүйцэтгэлтэй байна.

Удаа дараа тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв батлагдаагүй шалтгаанаар тендер зарлаагүй, төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжээгүй, төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу, техникийн тодорхойлолтод заасан шалгуур, чанарт нийцээгүй зэргээс шалтгаалан 930.2 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.

Сумдын ИТХ-аар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 367 төсөл арга хэмжээнд 11,275.6 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Сумдын хэмжээнд 2022 онд 1,132.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 62 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Энэ нь малын орлогын татварын гүйцэтгэл 65 хувь буюу бүрэн төвлөрөөгүйгээс санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан, тендер зарлаагүй, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл үүсээгүй гэх мэт хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Эндээс дүгнэж үзвэл сумд төсөл арга хэмжээний төлөвлөлтийг оновчтой төлөвлөж, зохион байгуулж чадахгүй байгааг илтгэж байна.

Г.1.1 Их засварын 7 төсөл арга хэмжээнээс 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий засварын ажил хийгдээгүй байна.

Тайлант онд их засварын зардлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтад 7 төсөл арга хэмжээнд 775.0 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 6 төсөл арга хэмжээний санхүүжилт 715.5 сая төгрөг буюу 94.8 хувьтай байна.

Хүснэгт №7 Их засварын зардлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Гүйцэтгэл	Хувь
1	Ус цаг уур орчны шинжилгээний албаны барилгын засвар	2022	33.0	33.0	32.6	99
2	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баяндэлгэр сум/	2022	207.0	207.0	196.1	95
3	Цэцэрлэгийн гаднах тохижилт / Халзан сум/	2022	20.0	20.0	20.0	100
4	Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заалны шалны засвар /Уулбаян сум /	2022	20.0	20.0	0.0	0
5	Цэцэрлэгийн барилгын их засвар / Баруун-Урт сум, 3-р цэцэрлэг/	2022	290.0	180.0	180.1	100
6	Соёлын төвийн барилгын их засварын ажлын санхүүжилт / Асгат сум/	2020-2022	201.7	201.7	180.0	89
7	Боловсрол өргөө нэгдсэн дотуур байрны дээврийн их засвар /Баруун-Урт сум /	2022	113.3	113.3	106.6	94
НИЙТ ДҮН			885.0	775.0	715.5	92

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заалны шалны засварын ажлыг 2023 оны хөрөнгө оруулалтын зардалд шилжүүлэн баталсантай холбоотойгоор хэрэгжээгүй байна. Энэ нь тухайн сургуулийн 872.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий их засварыг 2023 онд хийж гүйцэтгэх бөгөөд өвсний үндэс төслөөс 740.0 сая төгрөг, их засварын зардлын хөрөнгө оруулалтаар 132.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой байна.

Г.1.2 Удирдлагыг хэрэгжүүлэх зардал 78 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2 төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.

Удирдлага болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаар шилжиж ирсэн 4, шинээр хэрэгжих 8 нийт 12 төсөл арга хэмжээг 616.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт № 8 Удирдлага болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаар гүйцэтгэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Гүйцэтгэл	Хувь
1	Стандарт хэмжилзүйн хэлтсийн хэмжүүр, хэмжих хэрэгслийн эталон багаж хэрэгслийн шинэчлэл	2020-2022	55.0	55.0	46.5	85
2	Аймгийн төвийн худалдааны төвүүдэд камержуулалт / Баруун-Урт сум/	2020-2022	10.5	10.5	10.5	100
3	Тусгай зориулалтын автомашинуудын автограш барих /Онцгой байдлын газар/	2021-2022	314.1	150.4	10.0	7
4	Сүхбаатар аймгийн 80 жилийн ойд зориулсан музейн сан хөмрөгийн баяжуулах, мөнгөн урлалын үзэсгэлэн зохион байгуулах	2021-2022	90.0	50.0	-	-
5	Өвс тэжээл нөөц бүрдүүлэх, өр барагдуулах	2022	100.0	100.0	100.0	100
6	Гэр төсөл хэрэгжүүлэх/ Баруун-Урт, Халзан, Уулбаян, Дарьганга/	2022	170.0	170.0	158.4	93
7	Гэр төсөл хэрэгжүүлэх / Баруун-Урт сум/	2022	30.0	30.0	29.4	98
8	Гэр дулаалга хөтөлбөр хэрэгжүүлэх /Баруун-Урт сум 3-р баг/	2022	70.0	70.0	-	-
9	Нийтийн эзэмшлийн орон сууцны ус зөөлрүүлэх тоног төхөөрөмжийн дэмжлэг / Уулбаян сум/	2022	10.0	10.0	9.8	98
10	Соёлын төвд эд хогшил худалдан авах/ Уулбаян сум/	2022	10.0	10.0	10.0	100
11	Хилийн торны шинэчлэл / Эрдэнэцагаан, Онгон сум/	2022	140.0	140.0	140.0	100
12	Жимс жимсгэнэ үржүүлгийн газрын цахилгаан 10/04 кВ-ын 50 кВа чадалтай агаарын КТПН дэд өртөө /Баруун-Урт сум/	2022	36.0	36.0	35.4	98
НИЙТ ДҮН			656.0	616.0	483.0	78

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

Гүйцэтгэлээр 12 төсөл арга хэмжээний санхүүжилт 78 хувь ба 2 төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна. Үүнд:

- “Сүхбаатар аймгийн 80 жилийн ойд зориулсан музейн сан хөмрөгийг баяжуулах, мөнгөн урлагийн үзэсгэлэн зохион байгуулах” арга хэмжээний хүрээнд морины иж бүрэн хэрэглэл хийлгэхээр гүйцэтгэгчтэй 2021 онд гэрээлэн урьдчилгаа төлбөр олгосон бөгөөд тайлант онд гэрээний ажлыг хийж дуусгаагүй тул санхүүжүүлээгүй байна.
- “Гэр дулаалга хөтөлбөр хэрэгжүүлэх” арга хэмжээний бараа ажил үйлчилгээг тайлант онд бэлтгэн нийлүүлээгүй тул арга хэмжээний холбогдох санхүүжилтийг зогсоожээ

Тайлант онд 4 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн бөгөөд 5 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 85-98 хувьтай хэрэгжжээ.

Г.1.3 Авто замын сангаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ 85 хувийн гүйцэтгэлтэй байна.

Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн 1, шинээр хэрэгжүүлэх 4 нийт 5 төсөл, арга хэмжээг 570.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Тухайн жилд авто замын санг 570.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 4 төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгож, гүйцэтгэл 416.6 сая төгрөг буюу 85 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №9 Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа	төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Гүйцэтгэл	Хувь
1	Хорооллын дундах сайжруулсан зам/ Баруун-Урт сум, 7-р баг, Эко хороолол/	2021-2022	150.0	50.0	37.8	76
2	Баруун-Урт сумын төв болон хот хоорондын төв магистрал замуудын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг, шалгалт хийж, стандартад нийцүүлэн засаж өөрчлөх	2022	27.2	27.2	22.0	81
3	Зэвсэгт хүчний 338 дугаар анги хүртэлх хатуу хучилттай автозам / Баруун-Урт сум,/	2022	751.8	404.0	347.9	86
4	Хорооллын дундах автозам дагуух 800 м явган зам / Баруун-Урт сум/	2022	80.0	80.0	0.0	0
5	Авто тээврийн улсын үзлэг тооллого, оношилгооны зардал	2022	8.8	8.8	8.8	100
НИЙТ ДҮН			1,017.8	570.0	416.6	73

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

“Баруун-Урт сумын хорооллын дагуух 800м явган зам” төсөл арга хэмжээ 2022 онд тендер зарлаагүй, он дамжиж ажил гүйцэтгэгдэх урьдчилсан нөхцөл үүссэнээс шалтгаалан хэрэгжээгүй бөгөөд 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг баталжээ.

БҮЛЭГ 5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, танилцуулгын хамт бэлтгэгдээгүй байна

Д.1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан зарим шалгуурт нийцүүлэн тайлагнаагүй байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлангаар 16 хөтөлбөр, арга хэмжээнд 50,520.1 сая төгрөгийг зарцуулж, биелэлт 84 хувьтай байна.

Хүснэгт № 10 Төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр/ (сая төгрөг)


Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70105- ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	2,835.4	2,653.2	182.2	94
70106- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	42,123.1	35,391.1	6,732.0	84
70202- Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага	286.4	277.2	9.2	97
70426- Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	266.1	265.2	0.9	100
71101- Авто зам	570.0	416.6	153.4	73
71401- Хог хаягдал	1,954.9	1,941.7	13.3	99
71403- Ойжуулалт	66.6	66.6	-	100
71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	926.4	850.9	75.5	92
71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	536.3	420.4	115.9	78
71701-Биеийн тамир спорт	615.6	504.1	111.5	82
71702-Соёл урлаг	1,160.0	1,046.6	113.4	90
71801-Сургуулийн өмнөх боловсрол	2,172.1	2,041.1	130.9	94
71802-Ерөнхий боловсрол	3,801.0	3,540.2	260.8	93
71804-Мэргэжлийн боловсрол	281.6	281.6	0.0	100
71902-Нийгмийн халамж	135.5	135.5	-	100
72101-Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,195.8	688.2	1,507.6	31
НИЙТ ДҮН	59,926.7	50,520.1	9,406.7	84

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс

Төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, төсвийн захирагч бүрээр бэлтгэж батлуулаагүй, гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5¹⁸ дах заалт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”, 2012 оны 244 дүгээр тушаал “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай”-тай тус тус нийцээгүй байна.

БҮЛЭГ 6. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ

Диаграм №1 Орон нутгийн нэгдсэн төсвийн нэмэлт төсвийн санхүүжилт (сая.төг)



Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны нэмэлт төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөөс 320.9 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 196.7 сая, дээд шатны төсвийн захирагчаас 818.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 802.6 сая нийт 2,139.0 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшил 25.4 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.7 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 33.1 сая, хангамж, бараа материал 61.6 сая, нормативт зардал 3.1 сая, эд хогшил, урсгал засвар 51.7 сая, албан томилолт 12.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 636.4 сая, бараа үйлчилгээний бусад зардал 984.0 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 170.6 сая нийт 1,980.8 сая төгрөг зарцуулж, эрүүл мэндийн төвүүдийн тайланг орон нутагт нэгтгэхгүй болсонтой холбоотойгоор өмнөх оны үлдэгдэл 55.3 сая төгрөгийг холбогдох байгууллага руу шилжүүлэн, үлдэгдэл 158.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №3 Орон нутгийн нэгдсэн төсвийн нэмэлт төсвийн гүйцэтгэл (сая.төг)

¹⁸ Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна

Зардлын үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,194.2
УРСГАЛ ЗАРДАЛ	2,194.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,810.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33.1
Хангамж, бараа материалын зардал	61.6
Нормативт зардал	3.1
Эд хогшил, урсгал засварын зардал	51.7
Томилолт, зочны зардал	12.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	636.4
Бараа үйлчилгээний бусад зардал	984.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	384.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	170.6
Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	55.3
Төвлөрүүлэх шилжүүлэг	158.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗД-ын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

6.3 Нэмэлт төсвийн 17.5 хувийг бараа ажил үйлчилгээний зардалд, 82.5 хувийг урсгал шилжүүлэгт тус тус зарцуулсан байна.

---o0o---

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

ДҮГНЭЛТ

- Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүнг 59,926.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс 52,689.4 сая төгрөг буюу 88 хувийн гүйцэтгэлтэй байна
- Сүхбаатар аймгийн 2022 оны төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 50,520.1 сая төгрөг буюу 84.3 хувийн гүйцэтгэлтэй байна
- Төсөл арга хэмжээний зураг төсөв боловсрогдоогүй, тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, шалгуур хангаагүй зэрэг шалтгаанаар 13 арга хэмжээний 930.2 сая төгрөг олгогдоогүй үлдсэн байна
- Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд нийт 277.9 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн байна
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан зарим шалгуурт нийцүүлэн тайлагнаагүй байна
- Тайлант онд 451 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 24,944.3 сая төгрөгийг баталжээ
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас төвлөрсөн 13,816.4 сая төгрөг орлогоос Сангийн яам орон нутгийн төсөвт 9,637.2 сая төгрөгийг хуваарилж, үлдэгдэл 4,183.2 сая төгрөгийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, зээлийн хүүгийн төлбөрт суутган тооцсон байна.

- Нэмэлт санхүүжилтийн дансанд 2,139.0 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрч, 1,980.8 сая төгрөг зарцуулж, Эрүүл мэндийн байгууллагын үлдэгдэл 55.3 сая төгрөгийг холбогдох байгууллага руу шилжүүлэн, үлдэгдэл 158.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс:

1. Төсвийн орлогын төлөвлөгөө тасарч байгаа нь төсвийн орлогын төлөвлөлттэй холбоотой байгааг харуулж байна. Иймд төсвийн төлөвлөлтийг Сангийн яам болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран бодитой төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
2. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж, ижил нэр төрлийн барааг багцлан нийт төсөвт өртгөөр ХАА-г зохион байгуулах
3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой шаталсан сургалт зохион байгуулж, арга зүйгээр төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагыг хангах
4. Тухайн жилийн төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр бэлтгэн ИТХ-аар батлуулж, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн гүйцэтгэлийг аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт Төрийн аудитын байгууллагад тайлагнах

Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газарт:

1. Нэр дурдсан ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн, орон нутгийн санхүүгийн дэмжлэгээс бусад орлогын эх үүсвэргүй, өөрийгөө санхүүжүүлэн бие даан үйл ажиллагаа явуулах чадамжгүй газруудад дүн шинжилгээ хийж, хуулийн дагуу арга хэмжээ авах

Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 08 дугаар сарын 30-ны дотор багтаан Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

САНАЛ:

Хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах саналыг ҮАГ-ын холбогдох нэгжид уламжилж байна. Үүнд:

- Төсөвт байгууллага бараа худалдан авахтай холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэх чиглэлээр зөвлөмж өгч байгаа бөгөөд уг асуудлыг яаралтай горимоор шийдвэрлэхийг уламжлах

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэж заасны дагуу худалдан авалт хийхээр хандахад уг бараа бүтээгдэхүүн үнэтэй байдаг нөхцөлүүд гарч байна. Тухайлбал: Цахим дэлгүүрт double-A бичгийн 1 багц цаас 18000 төгрөгтэй байхад бусад дэлгүүрүүдэд 14000 төгрөгтэй зарагддаг зэргээс шалтгаалан хуулийн хэрэгжилтийг хангахад хүндрэл үүсэж байна. Иймд барааг худалдан авахтай холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
- Автомашин ашиглах болон түүнтэй холбогдон гарсан Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллагыг дотоод аудит хийлгэх чиглэлээр зөвлөмж өгөх нь зүйтэй байна.
- Сангийн сайдын 2022 оны А7 дугаар тушаалаар батлагдсан “ААНОАТ-ын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын 3.8 дахь заалт нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10 дахь заалттай нийцэхгүй байгааг уламжилж өгөх



Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, Факс: 70512121, 70518232

2023.05.03 № 01/603
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

“Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна.

А.1 Орон нутгийн төсөвт төвлөрөөгүй 4,183.2 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг санхүүгийн тайланд гүйцэтгэлээр илэрхийлж, орлогыг илүү тайлагнасан. Төсвийн гүйцэтгэлийн тайланд эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, зээлийн хүүгийн төлбөр 4,183.2 сая төгрөгийг орхигдуулсан.

Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудаас 2022 оны төсвийн жилд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар 40,968,8 (Дөчин тэрбум есөн зуун жаран найман сая найман зуун) мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд Төсвийн тухай хуульд заасны дагуу 40 хувь болох 16,387,5 (Арван зургаан тэрбум гурван зуун наян долоон сая таван зуун) мянган төгрөг орон нутгийн төсөвт орно гэж тооцсон.

Хууль тогтоомжийн дагуу дээрх орлогыг орон нутгийн төсөвт авах талаар Сангийн яамны холбогдох мэргэжилтэн, хэлтэс, газрын дарга, Төрийн нарийн бичгийн дарга, Сангийн сайдтай хариуцсан хэлтсийн дарга болон аймгийн удирдлагууд удаа дараа биечлэн уулзаж, албан бичиг хүргүүлэн ажилласан. Сангийн яамнаас журмын дагуу төлөвлөсөн хэмжээнд л өгнө, илүүг олгохгүй гэдэг байр сууринаас хандаж хариу өгч байсан.

Олон удаагийн уулзалт, ярилцлагын дүнд 9,637,2 (Есөн тэрбум зургаан зуун гучин долоон сая хоёр зуун) мянган төгрөгийг орон нутгийн төсвийн дансанд авч төсвийн жил дууссан. Төсвийн жил дуустал Сангийн яамнаас албан ёсны хариу өгөөгүй учир ИТХ-аар хэлэлцэх боломж гараагүй.

Төсвийн жил дууссан учир дансаар авах нөхцөл үүсэхгүй болсон учир ААНОАТ-ын үлдэгдлийг аймаг орон нутгийн эрх ашгийн үүднээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн ерөнд суутгуулан тооцох боломжийг эрэлхийлж Сангийн яаманд санал тавьж ярилцсанаар 4,183,2 (Дөрвөн тэрбум нэг зуун наян гурван сая хоёр зуун) мянган төгрөгийг ерөнд суутгуулсан. Хуулийн дагуу орон нутгийн төсөвт орох орлогыг ингээд орхих нь үнэхээр хайран байсан учир Засаг дарга миний хувьд Сангийн яамныхантай тохирч зээлийн ерөндөө суутгуулах нь эцсийн боломжтой хувилбар байсан.

Дээрх төлбөрийг 2023 он гарснаас хойш тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан бөгөөд Сангийн яамны зөвлөмж чиглэлийн дагуу уг суутгасан дүнг орон нутгийн ерөнхий дансны мөнгөн гүйлгээний тайланд 4,179.1 сая төгрөгөөр ААНОАТ-ын орлогыг нэмэгдүүлж, 230001 эдийн засгийн ангилал буюу эргэн төлөгдөх зээл зардалд бүртгэж тайлагнасан. Энэ дүнгээр Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдах бөгөөд

манай тайланг Сангийн яаманд нэгтгэхдээ цэвэрлэх бичилт хийгдэнэ. (Аймгийн төсвийн ерөнхий данс нь төсвийн байгууллагын статусгүй учир зарлагын дүн төсвийн гүйцэтгэлийн тайланд татагдахгүй байгаа болно.)

Б.2.2 Зөврийн компьютерыг 185.0 сая төгрөгөөр худалдан авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.2-т Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгон төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан “Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 42-т Төрийн санд “Эрхийн бүртгэлийн сан” системийг ашиглаж цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх, төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналыг УСНББОУСтандартад нийцүүлж, онлайн горимд шилжүүлэх, техникийн шинэчлэл хийх гэсэн заалтын дагуу судлан үзэж 2022 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” тогтоолоор батлагдсан төсвийн хүрээнд аймгийн хэмжээний төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын программыг УСНББОУ-ын стандартад нийцсэн, хууль тогтоомжийг шинэчлэлийг тусгасан, нягтлан бодогчид болон төрийн сангийн үйл ажиллагааг хөнгөвчилсөн CTS программаар шинэчлэн орон нутгийн төсвийн байгууллагууд, сумдын соёлын төвүүд, соёлын байгууллагууд, сумын эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлсэн. Энэ программ хангамж нь онлайн горимд ажиллах боломжтой, няравын тайлан нь нягтлан бодогчийн тайлантай уялдсан, байгууллагын гүйлгээ төрийн сангийн төлбөр тооцооны tools, санхүүгийн тайлан нь э-тайлан системд хөрвөх боломжтой зэрэг нягтлан бодогчийн ажлын ачааллыг багасгаж үр дүнг нэмэгдүүлсэн давуу талуудтай. Тус программыг дараах аймгуудад өмнөх жилүүдэд нэвтрүүлсэн. Тухайлбал: Архангай - 100, Булган-184, Сэлэнгэ-195, Дархан-Уул-99, Хэнтий-226, Завхан-144, Дорноговь-221, Ховд-141, Орхон-88, Өмнөговь-136 хэрэглэгчтэй.

Няравын тайлан нягтлан бодох бүртгэлийн программ руу автоматаар татагдах, онлайн ажиллах боломжтой учир няравт тусдаа компьютер шаардлагатай болсон. Нярав тусдаа компьютертой, тайлангаа программаар гаргах болсноор санхүүгийн мэдлэг боловсрол, ур чадвараа сайжруулах, үүрэг хариуцлагаа өндөржүүлэх, НББ-ийн анхан шатны бүртгэл сайжрах өндөр ач холбогдолтой гэж үзсэн.

Сумдын соёлын төвүүд, соёлын байгууллагууд, сумдын эрүүл мэндийн төвүүдэд зөврийн компьютер, программ хангамжаар хангасан тухайд бол Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.18-д төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар нь орон нутгийн чиг үүрэгт хамаарахаар, Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3.Газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс үл хөдлөх эд хөрөнгөд хамаарна. 84.4.Энэ хуулийн 84.3-т зааснаас бусад эд юмс хөдлөх эд хөрөнгөд хамаарна. 84.5.Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь эдийн бус хөрөнгөд хамаарна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д “орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг болон орон нутгийн чиг үүрэг, төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагын нийлбэрийг; 57 дугаар зүйлийн 57.1-д Орон нутгийн төсөвт хуваарилах орлогын нэр төрлийг энэ хуулиар, орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай

хуулиар зохицуулна, 58 дугаар зүйлийн 58.1-д Энэ хуулийн 4.1.30-д заасан орон нутгийн төсвийн суурь зарлагыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

58.1.1.аймаг, сум, нийслэл, дүүрэг татварын болон татварын бус орлого, 58.1.2.улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг,58.1.3.улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 орон нутгийн өмчийн соёлын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад нэмэлт санхүүжилт олгох гэсэн заалтуудад нийцүүлэхийн зэрэгцээ сумдын төсвийн байгууллагуудын төсөв санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, Засгийн газар, Орон нутгийн захиргааны байгууллагын дунд, богино хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор нэг удаа нийт байгууллагуудыг хамруулж энэ үйл ажиллагааг хэрэгжүүлсэн юм. Энэ хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн сайн байгаа бөгөөд улам боловсронгуй болгон ажиллана.

Төсвийн байгууллагуудын программ, техник хангамжийг сайжруулах зардал нь тухайн байгууллагуудын 2022 оны төсөвт тусгагдан батлагдсан учир худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулаагүй болно.

Аудитын тайланд тусгагдсан дээрхээс бусад асуудал зөвлөмжтэй санал нэг байгаа бөгөөд 2023 оны ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

1. Аудитын явцад дээрх асуудлаар холбогдох албан тушаалтнуудаас тайлбар авч, нотлох баримтаар баталгаажуулсан тул аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
2. Б.2.2 дахь дүгнэлтийг өөрчлөн найруулав.





СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/13


Баруун-Урт сум

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Н.Болдбаатар)-т үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, биелэлтийг 2023 оны 08 сарын 30-ны өдрийн дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Идэрбат), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал)-д зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Ө.Золзаяа), аудитор (О.Барчидгүнсэн) нарт үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

D:/Bichig hereg/2023/tushaal

